

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12 Шилэн дансны мэдээлэл	8
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ СОЛОНГОСЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЦЭГМИД ТАНАА

2020.02.20 № 06/546
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Тус коллеж нь кассаар бэлнээр авсан оюутны сургалтын төлбөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүй, төсөвт зардлын зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн анхан шатны баримт бүрдүүлэлгүйгээр 41,990.0 мянган төгрөг зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 16.5.5, болон Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3.6 заалт, 2017 оны 347 дугаар тушаал, 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 заалтыг тус тус зөрчиж, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Х.Цэгмид Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цаашид мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үргүй зардал гаргахгүй байх, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам зааврыг мөрдөж ажиллах, бүртгэл тайлагналыг сайжруулах, байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах талаар Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян Суварга Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Солонгосын Политехник Коллеж 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн САГ-2020/28/СТА-ТШЗ

тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Солонгосын Политехник Коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага, Монгол орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд өрсөлдөх, хөрвөх чадвар бүхий хүмүүнлэг ардчилсан нийгмийн харилцаанд төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэх, нийгмийн үйлчилгээний орчин бүрдүүлж иргэдэд үйлчлэхэд оршино”.

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын 2012 оны 19 дүгээр тушаалаар Монгол Солонгосын Политехник Коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах,
- Захиалгат болон насанд хүрэгчдэд мэргэжил олгох сургалт.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус коллежийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Солонгосын Политехник Коллеж санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Монгол Солонгосын Политехник Коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Солонгосын Политехник Коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,404,859.1 мянган төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс материаллаг байдлын түвшнийг тооцсон тул мөнгөн дүнгийн хувьд өөрчлөлт орсон болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцон 38,871.8 мянган төгрөгөөр тогтоосон нь эрсдэлийн түвшинтэйгээ уялдуулсан болно.

2.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 666,406.0 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /2-1/
Б	1	2	3
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	-	150,839.5	150,839.5
Бараа материал	557,505.6	490,294.0	(67,211.6)
Нөөцийн бараа			
Үндсэн хөрөнгө	13,926,340.9	13,176,307.0	(750,033.9)
Нийт хөрөнгө	14,483,846.5	13,817,440.5	(666,406.0)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	14,483,846.5	13,817,440.5	(666,406.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,483,846.5	13,817,440.5	(666,406.0)

Авлага дансны нийт үлдэгдэл 150,839.5 мянган төгрөгөөр өссөн нь 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөгдөөгүйгээс үүссэн авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 67,211.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд худалдаж авсан бараа материалыг 2019 онд зарцуулж тайлагнасангай холбоотой байна. Тайлант хугацаанд 267,047.6 мянган төгрөгийн материал худалдан авч, 334,259.2 мянган төгрөгийн материалын зарлага гарч 490,294.0 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагийн ихэнх нь жил бүр хуримтлагдсан үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 750,033.9 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын зөвшөөрөлтэйгээр 144,700.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, төсвийн захирагч нарын хооронд балансаас балансад 14,724.5 мянган төгрөгийн автомашин шилжүүлсэн элэгдлийн зардал зэргээс шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үнэ буурсан нь программ хангамжийн тайлант үеийн хасагдуулдагас шалтгаалсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,710,697.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,617,697,7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 93,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 2,617,697.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос бүрэн олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 93,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс 140,721.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 47,721.4 мянган төгрөгөөр давуулан биелсэн нь суралцагсдын тоо нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,694,499.1 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл:

Өөрийн орлогыг кассаар шууд захиран зарцуулснаас дараах зардлууд бүлгийн дүнгээр хэтэрсэн байна. Үүнд:

- Хангамжийн материалын зардал 6,541.8 мянган төгрөгөөр,
- Нормативын зардал 2,308.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 53,9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 15,659.9 мянган төгрөгөөр,

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,694,499.1 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаа нь төсөв хэтрээгүй тайлагнагдсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Койка олон улсын байгууллагаас 132,300.0 мянган төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зориулалтаар мөн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос тус коллежийн ажиллагсдын урамшуулалт цалин, нийгмийн асуудал шийдвэрлэхэд зориулан улсын төсвөөс 39,749.2 мянган төгрөг, хуваарилагдан ирж, Хөгжлийн бэрхшээлтэй оюутны дотуур байрыг засварлахад 133,287.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 12,101.4 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 26,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 36 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 87,985.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 45,995.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,564.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 17,426.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1.Тус коллежийн анги удирдсан багшийн тооцоо, сургалтын албаны мэдээг харилцахын хуулгатай тулгалт хийж үзэхэд төгссөн суралцагчдын төлбөрийн дутууг санхүүгийн тайланд тусгаагүй 29,585.0 төгрөг, мөнгөн хөрөнгийн дансны орлогод тусгалгүй зарцуулсан 16,410.0 мянган төгрөгийн зардлыг тус тус залруулан тайлан бүртгэлд тусгасан.

2. Тус коллеж 2019 оны батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр 16,198.5 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч төсөвт зардлын зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр 24564,5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 16.5.5, болон Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3.6 заалт, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитаар илэрсэн 41,990.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 24564,5 мянган төгрөгийн албан шаардлага 17,426.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг худалдан авахад хуулийн дагуу тендер зарласан эсэх, хичээл үйлдвэрлэлийн дадлагын ажилд олгосон бараа материалын зарцуулалт, үр дүнг тооцож дадлагын хичээлийн үр дүнд бий болгосон бүтээгдэхүүнийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Монгол Солонгосын Политехник Коллеж Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж, шатахуун зарцуулалтын тооцоог зохих журмын дагуу бодоогүй болон төсөвт зардлыг бүлгийн дүнгээр хэтрүүлсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай ” дүгнэлт

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй алдаа нь 41,990.8, мянган төгрөгийн алдаа нь бидний тооцсон 38,871,8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал,

санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тус коллежийн кассаас бэлнээр зарцуулсан мөнгөн хөрөнгөнд аудит хийж үзэхэд анхан шатны баримт дутуу, хүчин төгөлдөр бус 9,056.3 мянган төгрөгийн мөнгөн зарцуулалтыг хүлээн зөвшөөрч зардалд бүртгэсэн. Мөн батлагдсан төсөвгүй, мөнгөн урьдчилгааны тайлангийн маягт хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл:

Мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайланд тавих дотоод хяналт суларч, хөрөнгийн ашиглал, шамшигдал үүсэх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтыг бүрэн хөтөлж, зардлын төсвийг батлуулан мөнгөн урьдчилгааны тайлан гаргах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. *Бараа материалын данстай холбоотой асуудал*

3.2.1. Илрүүлэлт:

Шатахууны зарцуулалтын тооцоог үзэхэд 8,370.0 мянган төгрөгийн шатахууныг орлогод авсан боловч /НХМаягт БМ-6/ жолоочийн тооцооны хуудас /НХМаягт Т-4/-ыг хөтлөөгүй, техникийн комиссыг акт үйлдэж автомашины техникийн паспортыг хөтөлж шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасан, мөн Дэд бүтцийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2004 оны 19 дүгээр тушаалын 1, 9 дүгээр хавсралтын заалттай тус тус нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, хууль эрхийн акт зөрчигдөх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид жолоочийн тооцоог бодож, автомашины техникийн комиссын акт үйлдэж паспортыг хөтөлж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	557,505,589.29	641,133,455.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	150,839,500.00
335	Бусад авлага	-	150,839,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		150,839,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	557,505,589.29	490,293,955.29
351	Түүхий эд материал	423,599,922.50	361,346,938.50
35110	Тусгай зориулалттай материал	423,011,552.50	361,294,718.50
35130	Эм боох материал	588,370.00	52,220.00
354	Хангамжийн материал	133,905,666.79	128,947,016.79
35410	Бичиг хэргийн материал	7,936,965.00	4,198,515.00
35420	Аж ахуйн материал	124,863,701.79	123,899,701.79
35430	Сэлбэг хэрэгсэл	365,000.00	108,800.00
35450	Барилгын засварын материал	740,000.00	740,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,926,340,918.97	13,176,307,046.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,926,340,918.97	13,176,307,046.03
391	Газар		
392	Биет хөрөнгө	13,323,685,552.04	12,577,101,679.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,764,448,987.00	10,896,748,987.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	174,438,738.25	450,281,790.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,836,881.86	210,112,411.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	98,173,835.64	119,710,448.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,068,433,725.59	4,124,895,469.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	2,288,845,489.50	2,784,499,939.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	842,408,406.79	776,616,908.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	370,539,269.67	403,238,924.56
39209	Зам, гүүрийн байгууламж	304,667,000.86	304,667,000.86
39210	Хуримтлагдсан элэгдэл		29,445,877.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,590,668.28	1,590,668.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	1,590,668.28	1,590,668.28
39217	Ном	50,887,883.00	51,237,883.00
393	Биет бус хөрөнгө	602,655,366.93	599,205,366.93
39301	Програм хангамж	25,650,000.00	25,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	9,558,333.07	13,008,333.07
39303	Бусад биет бус хөрөнгө	586,563,700.00	586,563,700.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,483,846,508.26	13,817,440,501.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,483,846,508.26	13,817,440,501.32
51	Засгийн газрын хувь оролцоо	14,483,846,508.26	13,817,440,501.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,790,616,010.16	1,790,616,010.16
51101	Өмч: - төрийн	1,790,616,010.16	1,790,616,010.16
512	Хуримтлагдсан үр дүн	7,720,589,877.20	7,079,573,680.97
51210	Өмнөх үеийн үр дүн	8,566,544,037.35	7,745,979,687.91
51220	Тайлант үеийн үр дүн	(845,954,160.15)	(666,406,006.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,972,640,620.90	4,947,250,810.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,483,846,508.26	13,817,440,501.32

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,558,904,987.91	3,220,775,860.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	328,716,887.91	602,628,160.00
120	Нийтлэг татварын бус орлого	328,716,887.91	602,628,160.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	328,716,887.91	602,628,160.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,546,840.00	314,237,280.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,045,300.00	21,580,150.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	152,124,747.91	266,810,730.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,230,188,100.00	2,618,147,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,230,188,100.00	2,618,147,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,230,188,100.00	2,618,147,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,404,859,148.06	3,887,181,866.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,404,859,148.06	3,887,181,866.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,233,250,138.54	3,728,268,549.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,410,465,560.09	1,736,197,261.75
210101	Үндсэн цалин	1,410,465,560.09	1,703,007,748.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,498,253.00
210104	Урамшуулал		26,691,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,504,560.70	220,059,096.29
210201	Тэтгэврийн даатгал	108,388,039.38	163,776,057.30
210202	Тэтгэмжийн даатгал	13,283,053.38	14,522,114.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,843,425.51	12,610,089.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,632,112.31	3,148,869.91
210205	Эрүүл мэндийн даатгал	26,357,930.12	26,001,965.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,180,889.13	175,139,959.08
210301	Гэрэл, цахилгаан	55,551,418.00	58,802,674.51
210302	Түлш, халаалт	43,639,382.00	76,414,619.45
210303	Цэвэр, бохир ус	42,013,289.13	39,922,665.12
210304	Байрны түрээс	1,976,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	111,783,771.97	79,908,636.30
210401	Бичиг хэрэг	1,346,420.00	1,103,950.00
210402	Тээвэр, шатахуун	4,130,000.00	9,492,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,185,208.63	16,148,324.30
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,756,000.00	4,760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,366,143.34	48,404,362.00
2105	Нормативт зардал	116,824,915.00	128,569,845.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	295,800.00	970,640.00
210502	Хоол, хүнс	110,464,855.00	126,608,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,064,260.00	990,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,561,000.00	70,322,900.00
210604	Урсгал засвар	14,561,000.00	70,322,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,493,170.00	2,524,500.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,493,170.00	2,524,500.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,703,521.00	78,411,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,242,000.00	70,602,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	220,000.00	441,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,921.00	645,026.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,600.00	2,099,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,732,750.65	1,237,135,221.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,099.91	273,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	340,150,092.07	228,378,524.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	860,388,558.67	1,008,483,697.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	171,609,009.52	158,913,317.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,915,500.00	80,464,521.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	88,810,900.00	64,322,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,584,600.00	6,352,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	9,790,421.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,693,509.52	68,877,890.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,693,509.52	68,877,890.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,570,905.52
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		9,570,905.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(845,954,160.15)	(666,406,006.94)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(845,954,160.15)	(666,406,006.94)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,407,033,240.00</u>	<u>2,935,425,630.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,845,140.00	145,228,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	176,845,140.00	145,228,730.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	176,845,140.00	145,228,730.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,546,840.00	123,648,580.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,298,300.00	21,580,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,230,188,100.00	2,750,447,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,230,188,100.00	2,618,147,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,230,188,100.00	2,618,147,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	172,049,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		132,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хирээнд бий болсон нэмэлт орлого		39,749,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,341,400,240.00</u>	<u>2,934,215,630.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,341,400,240.00	2,934,215,630.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,169,791,230.48	2,785,590,558.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,316,671,287.96	1,740,169,504.30
210101	Үндсэн цалин	1,310,125,139.56	1,277,738,969.49
210102	Нэмэгдэл		294,046,392.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт		55,492,320.00
210104	Урамшуулал	6,546,148.40	112,891,822.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,312,274.79	216,804,193.74
210201	Тэтгэврийн даатгал	251,312,274.79	177,439,403.09
210202	Тэтгэмжийн даатгал		27,545,966.01
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,668,014.13
210204	Ажилгүйдлийн даатгал		1,759,003.28
210205	Эрүүл мэндийн даатгал		7,391,807.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,180,889.13	175,139,959.08
210301	Гэрэл, цахилгаан	55,551,418.00	58,802,674.51
210302	Түлш, халаалт	43,639,382.00	76,414,619.45
210303	Цэвэр, бохир ус	42,013,289.13	39,922,665.12
210304	Байрны түрээс	1,976,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	67,899,254.60	64,474,166.30
210401	Бичиг хэрэг	5,040,440.47	7,005,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,680,000.00	9,492,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,119,492.13	16,148,324.30
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,756,000.00	4,760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,303,322.00	27,068,692.00
2105	Нормативт зардал	116,282,055.00	134,800,805.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,937,200.00	890,000.00
210502	Хоол, хүнс	110,464,855.00	126,608,605.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,880,000.00	7,302,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,005,800.00	205,174,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,295,000.00	660,000.00

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	28,710,800.00	204,514,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,493,170.00	2,524,500.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,493,170.00	2,524,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,557,321.00	78,411,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,242,000.00	70,602,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	220,000.00	441,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,921.00	645,026.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	835,400.00	
210807	Газрын төлбөр		2,099,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,389,178.00	168,092,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	169,389,178.00	168,092,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	171,609,009.52	148,625,071.58
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,915,500.00	79,747,181.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	88,810,900.00	64,322,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,584,600.00	6,352,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	9,073,081.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,693,509.52	68,877,890.58
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,693,509.52	68,877,890.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>65,633,000.00</u>	<u>1,210,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,633,000.00	1,210,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,633,000.00	1,210,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,633,000.00	1,210,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,633,000.00	1,210,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(65,633,000.00)</u>	<u>(1,210,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,204,052,310.16	1,064,731,180.80	9,256,227,749.54	11,525,011,240.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн			(689,683,712.19)	(689,683,712.19)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,790,616,010.16	4,972,640,620.90	7,720,589,877.20	14,483,846,508.26
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,790,616,010.16	4,972,640,620.90	7,720,589,877.20	14,483,846,508.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			25,389,810.71	25,389,810.71
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,790,616,010.16	4,972,640,620.90	7,745,979,687.91	14,509,236,318.97
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		(25,389,810.71)		(25,389,810.71)
Тайлант үеийн үр дүн			(666,406,006.94)	(666,406,006.94)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,790,616,010.16	4,947,250,810.19	7,079,573,680.97	13,817,440,501.32

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,710,697,700.00	2,694,499,115.42	(16,198,584.58)	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,710,697,700.00	2,694,499,115.42	(16,198,584.58)	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,632,973,600.00	2,614,751,934.42	(18,221,665.58)	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,754,417,200.00	1,714,169,504.30	(40,247,695.70)	97.7
210101	Үндсэн цалин	1,186,456,300.00	1,251,738,969.49	65,282,669.49	105.5
210102	Нэмэгдэл	363,736,000.00	294,046,392.81	(69,689,607.19)	80.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,230,000.00	55,492,320.00	(20,737,680.00)	72.8
210104	Урамшуулал	127,994,900.00	112,891,822.00	(15,103,078.00)	88.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,302,100.00	216,804,193.74	(2,497,906.26)	98.9
210201	Тэтгэврийн даатгал	149,125,500.00	177,439,403.09	28,313,903.09	119.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,544,200.00	27,545,966.01	10,001,766.01	157.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,035,300.00	2,668,014.13	(11,367,285.87)	19.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,508,800.00	1,759,003.28	(1,749,796.72)	50.1
210205	Эрүүл мэндийн даатгал	35,088,300.00	7,391,807.23	(27,696,492.77)	21.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,180,600.00	175,139,959.08	(40,640.92)	100.0
210301	Гэрэл, цахилгаан	82,191,300.00	58,802,674.51	(23,388,625.49)	71.5
210302	Түлш, халаалт	66,528,400.00	76,414,619.45	9,886,219.45	114.9
210303	Цэвэр, бохир ус	26,460,900.00	39,922,665.12	13,461,765.12	150.9
2104	Хангамж, бараа материалын зардал	54,679,000.00	61,220,842.30	6,541,842.30	112.0
210401	Бичиг хэрэг	10,986,000.00	6,249,150.00	(4,736,850.00)	56.9
210402	Тээвэр, шатахуун	8,220,000.00	9,492,000.00	1,272,000.00	115.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,203,000.00	16,148,324.30	(1,054,675.70)	93.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,420,000.00	3,910,000.00	(4,510,000.00)	46.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,850,000.00	25,421,368.00	15,571,368.00	258.1
2105	Нормативт зардал	132,491,900.00	134,800,805.00	2,308,905.00	101.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	891,000.00	890,000.00	(1,000.00)	99.9
210502	Хоол, хүнс	126,674,700.00	126,608,605.00	(66,095.00)	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,926,200.00	7,302,200.00	2,376,000.00	148.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,963,500.00	71,963,500.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	737,000.00	737,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	71,226,500.00	71,226,500.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,524,500.00	2,524,500.00	-	100.0

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	2,524,500.00	2,524,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,982,700.00	70,036,630.00	53,930.00	100.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,803,000.00	62,228,400.00	425,400.00	100.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.00	4,600,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	445,000.00	441,504.00	(3,496.00)	99.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	915,900.00	645,026.00	(270,874.00)	70.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	118,800.00	22,000.00	(96,800.00)	18.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,099,700.00	(300.00)	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,432,100.00	168,092,000.00	15,659,900.00	110.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	152,432,100.00	168,092,000.00	15,659,900.00	110.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,724,100.00	79,747,181.00	2,023,081.00	102.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,724,100.00	79,747,181.00	2,023,081.00	102.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,322,100.00	64,322,100.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,352,000.00	6,352,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,050,000.00	9,073,081.00	2,023,081.00	128.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,710,697,700.00	2,550,870,150.00	(159,827,550.00)	94.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,617,697,700.00	2,410,148,700.00	(207,549,000.00)	92.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,617,697,700.00	2,410,148,700.00	(207,549,000.00)	92.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,000,000.00	140,721,450.00	47,721,450.00	151.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000,000.00	122,641,300.00	37,641,300.00	144.3
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	18,080,150.00	10,080,150.00	226.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	141	141		100.0
620001	Удирдах ажилтан	4	4		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	99	99		100.0
620003	Үйлчлэх ажилтан	38	38		100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		172,049,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		172,049,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		172,049,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,000,000.00
210104	Урамшуулал		26,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		-
210201	Тэтгэврийн даатгал		
2104	Хангамж, бараа материалын зардал		3,726,900.00
210401	Бичиг хэрэг		756,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,120,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		133,947,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		660,000.00
210602	Тавилга		
210604	Урсгал засвар		133,287,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,374,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,374,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		172,049,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		172,049,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		132,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		39,749,200.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020-02-14

Аудитын

Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2020/28/СТА-ТШЗ

Шагтагдсан байгууллагын нэр:

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

мянган төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал	1	2. Тус коллеж 2019 оны батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр 16,198.5 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч төсөвт зардлын зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр 24564.5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 16.5.5, болон Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3.6 заалт, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг зөрчсөн байна.	24,564.5	Албан шаардлага өгөх	2020.02.17		МСПТК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч	Х.Цэпмид П.Пүрэвдорж
2	Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал	1	Тус коллежийн кассаас бэлнээр зарцуулсан мөнгөн хөрөнгөнд аудит хийж үзэхэд анхан шатны баримт дутуу, хүчин төгөлдөр бус 9,056.3 мянган төгрөгийн мөнгөн зарцуулалтыг хүлээн зөвшөөрч зардалд бүртгэсэн. Мөн батлагдсан төсөвгүй, мөнгөн урьдчилгааны тайлангын маягт хөтлөөгүй байна.	9,056.3	Зөвлөмж өгөх	2020.02.17		МСПТК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч	Х.Цэпмид П.Пүрэвдорж
3	Бараа материалын данстай холбоотой асуудал	2	Шатахууны зарцуулалтын тооцоог үзэхэд 8,370.0 мянган төгрөгийн шатахууныг орлогод авсан боловч /НХМаягт БМ-6/ жолоочийн тооцооны хуудас /НХМаягт Т-4/-ыг хөтлөөгүй, техникийн комиссыг акт үйлдэж автомашины техникийн паспортыг хөтөлж шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй байна.	8,370.0	Зөвлөмж өгөх	2020.02.17		МСПТК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч	Х.Цэпмид П.Пүрэвдорж
		4		41,990.8					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 20

№ 02/05

Улаанбаатар хот

СМГ-2020/02/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус коллеж 2019 оны батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр 16 199.2 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр 24564,5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 16.5.5 дах заалт, сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3.6 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцэж байх гэсэн санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө", 4.1.3-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн", 4.1.6-д "Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн дараах Албан шаардлагыг доорх албан тушаалтанд хүргүүлж байна. **ТОГТООХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Alban Shaardлага\2020\02\21\5661 Docx

001080023

1. Аудитаар албан шаардлагыг 2020 оны 10 дугаар сарын 25-ны дотор хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Х.Цэгмидэд даалгаж байна.

АЛБАН ШААРДЛАГА


ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  С.БАТ-ЭРДЭНЭ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

“БАЯН СУВАРГА АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  С.ДОЛЖИНСҮРЭН

АУДИТОР  Х.ТУНГАЛАГТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ СОЛОНГОСЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

 Х.ЦЭГМИД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 П.ПҮРЭВДОРЖ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.